

НИЙСЛЭЛИЙН АГААР ОРЧНЫ БОХИРДОЛТОЙ ТЭМЦЭХ ГАЗАР

"АЛСЫН ХАРАА-2050" МОНГОЛ УЛСЫН УРТ ХУГАЦААНЫ ХӨГЖЛИЙН БОДЛОГЫН
2022 ОНЫ ХЭРЭГЖИЛТИЙН ТАЙЛАН


/2022 оны бүтэн жил /

Д	Зорилт	Арга хэмжээ	Хэрэгжих хугацаа	Зарцуулсан хөрөнгийн хэмжээ, эх үүсвэр (сая төгрөг)	Зорилтот түвшин, үр дүнгийн үзүүлэлт	Хүрсэн түвшин, үр дүн	Хэрэгжилтийн хувь / Дээд шатны байгууллагын үнэлгээ, тайлбар
9.2.	Иргэдийн эрүүл аюулгүй орчинд амьдрах нөхцөлийг бүрдүүлж, экосистемийн тэнцвэрт байдлыг хангасан, хүлэмжийн хийн ялгарал багатай ногоон технологи	9.2.4. Байгальд дэвшилтэт техник, нэвтрүүлэх замаар бүх эх үүсвэрийг багасгаж, дахин ашиглах саармагжуулах боломжийг бүрдүүлнэ.	2020-2050	Гадаадын зээл тусламж 899.0	Байгальд ээлтэй, дэвшилтэт техник, технологи	1. Засгийн газрын 2018 оны "Түүхий нүүрс хэрэглэхийг хориглох тухай" 62 дугаар тогтоолд нэмэлт өөрчлөлт оруулж 2022 оны 06 дугаар сарын 08-ны хуралдаанаар хэлэлцүүлж 223 дугаар тогтоолыг батлуулсан. Энэхүү тогтоолоор дулааны станц, дулааны цахилгаан станцаас бусад аж ахуйн нэгж, байгууллагуудын халаалтын зууханд түүхий нүүрс хориглож, мидлинг болон эрчим хүчний баяжуулсан нүүрс хэрэглэхээр болсон. 2. Байгаль орчин, аялал жуулчлалын яам, Орчны бохирдлыг бууруулах үндэсний хороо, Европын сэргээн босголт хөгжлийн банк болон Азийн хөгжлийн банкны санхүүжилтээр нийт 22 сургууль, цэцэрлэгийн 40 халаалтын зуухыг газрын гүний дулаан болон цахилгаан, хийн хангамжид шилжүүлэх ажил хийгдэж байна. 3. Байгаль орчин, аялал жуулчлалын яам, Нийслэлийн Засаг даргын тамгын газар хамтран "Агаар, орчны бохирдлыг бууруулах ногоон технологи-2022"	100%

<p>Бүхий амьдралын таатай орчинтой хот болно.</p>				<p>үзэсгэлэнг "Цэвэр технологи-Эрүүл орчин" уриатайгаар 2022 оны 10 дугаар сарын 08-09-ний өдрүүдэд Баянзүрх дүүргийн Нийслэлийн үйлчилгээний нэгдсэн төвд зохион байгуулан 40 гаруй аж ахуйн нэгж, байгууллагууд оролцон 250 орчим иргэдийг хамруулан, Хаан, Хас, Төрийн банк хөнгөлөлттэй нөхцөл бүхий "Ногоон зээл"-ийн үйлчилгээний талаар танилцуулж, иргэд уг банкуудаар үйлчлүүлж хөнгөлөлттэй зээлээр бүтээгдэхүүн худалдаж авах зэрэг олон боломжийг бүрдүүлсэн арга хэмжээг зохион байгуулсан.</p>	
<p>9.2.12. Орчны чанарын хяналт-шинжилгээний чадавхыг бэхжүүлэн судалгаа, шинжилгээний ажлыг өргөжүүлж, лабораторийн хүчин чадлыг нэмэгдүүлнэ.</p>	<p>Дэлхийн Банкны санхүүжилт зэр 1,400.0</p>	<p>Лабораторийн хэмжилтийн үйл ажиллагаанд MNS/ISO/IEC 17025:2018 олон улсын стандартыг нэвтрүүлэн, Орчны чанарын хяналт-шинжилгээний чадавхыг бэхжүүлэн судалгаа, шинжилгээний ажлыг өргөжүүлнэ.</p>	<p>Орчны чанарын хяналтыг сайжруулах ажлын хүрээнд Баянзүрх дүүргийн 9 дүгээр хорооны СЭМҮТөвийн орчим, Налайх дүүргийн 7 дугаар хороонд Франц улсад үйлдвэрлэгдсэн ENVIRONMENTAL-SA маркийн орчны агаарын чанарыг 13 үзүүлэлтээр тодорхойлох 2 суурин харуулыг суурилуулсан.</p> <p>Нийслэлийн Агаар, орчны бохирдолтой тэмцэх газрын дэргэдэх Агаарын чанарын хяналтын лабораторийг олон улсын MNS ISO/IEC 17025:2018 стандартын шаардлагыг хангасан итгэмжлэгдсэн лаборатори гэж 2022 оны 04 дүгээр сарын 28-ны өдөр ТЛ 176 дугаартай Итгэмжлэлийн гэрчилгээ олгосон.</p> <p>Нийслэлийн төвийн 7-н дүүрэгт үйл ажиллагаа явуулж байгаа уурын болон усан халаалтын зуух эзэмшигч аж ахуйн</p>	<p>100%</p>	
<p>2</p>	<p>2020-2050</p>				

					<p>нэгж, байгууллагын хүсэлтээр 2022 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс 11 дүгээр сарын 21-ний өдрийг хүртэлх хугацаанд нийт 39 зуух, 69 түлшний дээжинд хаягдал утааны хэмжилтийг хийж дүнг MNS5043:2016, MNS 5919:2009, MNS5457:2005 стандарттай харьцуулан хэмжилтийн боловсруулан холбогдох албан байгууллага ААНБ-д хүргүүлэн ажилласан.</p> <p>Сайжруулсан шахмал түлш үйлдвэрлэж байгаа иргэн, аж ахуй нэгжийн хүсэлтийн дагуу сайжруулсан шахмал түлшний үйлдвэрүүдийн бүтээгдэхүүн стандартын шаардлага хангаж буй эсэхэд хаягдал утааны хийн хэмжилт хийсэн.</p>
	<p>9.2.13. Авто тээврийн хэрэгслээс ялгарч байгаа хорт бодисын хэмжээг бууруулж, гэр хорооллын дахин төлөвлөлтийн ажлыг эрчимжүүлэн, агаарын бохирдлын идэвхжил ихтэй бүсийг орон сууцжуулах асуудлыг шат дараатай, системтэй хэрэгжүүлж агаарын бохирдлыг бууруулна.</p>	2020 - 2050	-	<p>Тээврийн хэрэгслийн яндангаас ялгаруулах хорт бодисын хэмжээг бууруулна.</p>	<p>Авто замын хөдөлгөөнд оролцож буй тээврийн хэрэгслийн нүүрсэн яндан буюу катализаторийн ажиллагааны байдлыг тодорхойлох зорилгоор Монгол улсын автозамын хөдөлгөөнд хамгийн их оролцож байгаа Тоёота приус маркийн тээврийн хэрэгслийг сонгож, үйлдвэрийн яндантай, Хятад улсын дууриамал яндантай, огт яндангүй гэсэн 3 төрлөөр яндангаас хаягдах, бохирдуулах бодисын хэмжээг тодорхойлох харьцуулсан хэмжилтийг 2022 оны 02 дугаар сарын 18-ны өдөр хийсэн. Хэмжилтийн үр дүнгээс үзэхэд үйлдвэрийн яндантай тээврийн хэрэгслээс агаарт хаягдах нүүрстөрөгч /CO/-ийн хэмжээ бага эргэлттэй үед огт яндангүй тээврийн хэрэгслээс хаягдах хэмжээнээс 4.5 дахин бага, Хятад улсын</p> <p style="text-align: right;">100%</p>

								дууриамал яндангаас 3.2 дахин бага байсан бол их эргэлттэй үед нүүрстөрөгч /CO/-ийн хэмжээ үйлдвэрийн яндангаас ялгарах хэмжээ огт яндангүй тээврийн хэрэгслээс 6.8 Хятад улсын дууриамал яндангаас 4.3 тус тус бага ялгаралтай байна.	
--	--	--	--	--	--	--	--	--	--

ХЯНАСАН:
ЗАХИРГАА, САНХҮҮГИЙН ХЭЛТСИЙН ДАРГА  О.АЛТАНГЭРЭЛ

ТАЙЛАГНАСАН:
ЗСХ-ИЙН МЭРГЭЖИЛТЭН



Б.НУРБАХЫТ

НИЙСЛЭЛИЙН АГААР ОРЧНЫ БОХИРДОЛТОЙ ТЭМЦЭХ ГАЗАР

"АЛСЫН ХАРАА-2050" МОНГОЛ УЛСЫН УРТ ХУГАЦААНЫ ХӨГЖЛИЙН БОДЛОГЫН ХЭРЭГЖИЛТИЙН ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ, ЗОРИЛТОТ ТҮВШИНГ ТАЙЛАГНАХ ХҮСНЭГТ

2022 оны 11 дүгээр сарын 23

Улаанбаатар хот

№	Шалгуур үзүүлэлт	Хэмжих нэгж	Суурь түвшин		Зорилтот түвшин		Тайлант хугацааны хүрсэн түвшин	Шалгуур үзүүлэлтийн тайлбар	Мэдээлэл цуглуулах арга зүй, эх үүсвэр	Тайлбар (Зорилтот түвшинд хүрээгүй бол шалтгаан нөхцөлийг)	Хариуцагч байгууллага
			Он	Түвшин	Он	Түвшин					
0	1	2	3	4	5	6	7	8	9	10	11
72	Улаанбаатар хотын агаар дахь PM2.5 тоосонцрын жилийн дундаж агууламж	мкг/м3	2018	64	2025	40	Улаанбаатар хотын агаар дахь PM2.5 тоосонцрын хэмжээ 33 мкг/м3, PM10 тоосонцрын хэмжээ 92 мкг/м3 байна.	PM2.5 тоосонцрын хэмжээ зорилтод түвшнээс 7 мкг/м3, суурь түвшнээс 31 мкг/м3-ээр тус тус буурсан үзүүлэлттэй байна.	Улаанбаатар хотын агаарын чанар хэмжих автомат суурин харуулууд	-	НАБТГ
73	Улаанбаатар хотын агаар дахь PM10 тоосонцрын жилийн дундаж агууламж	мкг/м3	2018	141	2025	50		PM10 тоосонцрын хэмжээ зорилтод түвшнээс 42 мкг/м3-аар ихссэн суурь түвшнээс 49 мкг/м3-ээр буурсан үзүүлэлттэй байна.		-	НАБТГ

ХЯНАСАН:


ЗАХИРГАА, САНХҮҮГИЙН
ХЭЛТСИЙН ДАРГА



О.АЛТАНГЭРЭЛ

ХЯНАЛТ, ШИНЖИЛГЭЭ ХИЙСЭН:

ХШУ, ХАМТЫН АЖИЛЛАГАА ХАРИУЦСАН
МЭРГЭЖИЛТЭН



Т.ЭНХМАА